



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/155

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах хүсэлт ирүүлсэн 2 иргэний гаргасан өргөдлийн дагуу 1.6008га (16008м²) газрын газар эзэмшүүлсэн аймгийн Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар хугацааг сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.


3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ





Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/А.55 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУГАЦАА СУНГАХ ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын талбайн хэмжээ (м ²)	Газрын байршил	Газрын зориулалт	Газар эзэмших хугацаа	Хүчингүй болгож буй шийдвэрийн огноо
1	Бөтүүл овгийн Батхүү Бадрах (РВ76122013)	6712014488	432	8-р баг 12-18а тоот	Гэр, орон сууцны хашааны газар	40	Аймгийн Засаг даргын 2008 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн №205 дугаар захирамжийн хавсралтын 17 дахь заалт
2	Хэрдэг овгийн Дэмбэрэл Мөнхдэлгэр (РС75101911)	6712016503	15576	13-р баг Бой	Зоорь	40	Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/154 дүгээр захирамжийн хавсралтын 18 дахь заалтын 8 дахь багана

Нийт талбайн хэмжээ-16008м²

[Handwritten signature]

-----oOo-----